



**“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2026 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 01

Хэрлэн сум

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн хурлын тэмдэглэлд:

**ХЭЛЭЛЦСЭН нь:**

Компанийн 2026 оны бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг дэмжих тухай

**ТЭМДЭГЛЭСЭН нь:**

Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”, Эрчим хүчний сайдын 2026 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн а/59 дүгээр албан бичгээр ирүүлсэн удирдамжийн дагуу компанийн 2026 оны бараа, ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг хэлэлцэв.

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК нь 2026 оны ХАА-ны төлөвлөгөөг батлагдсан зардалд багтааж, 10,836,737,408.00 төгрөгийн, 105 худалдан авалтыг хийхээр төлөвлөсөн. Үүнээс: хөрөнгө оруулалт – 17, их засвар – 4, ТЗБАХ – 4, ХАБЭА – 13, бараа худалдан авалт – 32, бусад ажил үйлчилгээ – 23, СЦТССалбарын худалдан авалт – 12 байна.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:**

1.Компанийн 2026 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд хэлэлцэн дэмжив.

2.”Компанийн 2026 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, хууль тогтоомжид заасан хугацаанд холбогдох газарт хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал Ө.Жаргалсайханд даалгав.

3.Компанийн 2026 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Шилэн дансны цахим системд хуулийн хугацаанд байршуулах, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, биелэлтийг хагас бүтэн жилээр Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахыг Гүйцэтгэх захирал Ө.Жаргалсайханд үүрэг болгов” гэжээ.

ДАРГА



О.ХУЯГЦОГ





“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 03

Хэрлэн сүм

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн хурлын тэмдэглэлд:

**ХЭЛЭЛЦСЭН нь:**

Компанийн ажилтнуудад 2025 оны жилийн үйл ажиллагааны үр дүнгээр олгох нэмэгдлийн тухай

**ТЭМДЭГЛЭСЭН нь:**

Компанийн 2025 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлтийг харгалзан 2025 оны жилийн үйл ажиллагааны үр дүнгээр олгох нэмэгдэл хөлсний дээд хэмжээг 3 сараар, дундаж хэмжээг 2.6 сараар тогтоож, нэмэгдэл хөлсийг батлагдсан санд багтаан нийт ажилтнууд болон гүйцэтгэх захиралд олгох асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд 100 хувийн саналаар дэмжсэн болно.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:**

1.”...2025 оны жилийн үйл ажиллагааны үр дүнгээр олгох нэмэгдэл хөлсний дээд хэмжээг 3 сараар тогтоож, нэмэгдэл хөлсийг батлагдсан санд багтаан компанийн нийт ажилтнуудад олгохыг Гүйцэтгэх захиралд зөвшөөрөв.

2.Гүйцэтгэх захиралд 2025 оны жилийн үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлс олгох саналыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд дэмжиж, олгохыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (О.Хуягцогт)-д зөвшөөрөв...” гэжээ.

ДАРГА



О.ХУЯГЦОГТ



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 04

Хэрлэн сум

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн хурлын тэмдэглэлд:

**ХЭЛЭЛЦСЭН нь:**

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай

**ТЭМДЭГЛЭСЭН нь:**

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2025 онд нийт 15 удаа хуралдан 33 асуудал хэлэлцэн шийдвэрлэж, 20 тогтоол, 13 тэмдэглэлээр холбогдох албан тушаалтнуудад үүрэг даалгавар өгсөн байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны шийдвэрийн биелэлт 94.2% байна.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:**

“...Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны ажлын тайланг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон нарийн бичгийн дарга нарт тус тус даалгав...” гэжээ.

ДАРГА



ОХУЯГЦОГТ